



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сүхлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comsol@iaac.mn, Веб сайт: http://iaac.mn

2022.05.12 № 05/6551
танай _____ -ны № _____ -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.ЗАЯАБАЛ ТАНАА

Нийслэлийн Хан-Уул дүүргийн татварын хэлтсийн Захиргаа, хуулийн тасгийн хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Жигжээгийн Ариунзул, Өмнөговь аймгийн татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Батбаярын Мягмарцэрэн, Нийслэлийн Багануур дүүргийн татварын хэлтсийн Захиргаа, хуулийн тасгийн хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Балдандоржийн Оюунчимэг, Увс аймгийн татварын хэлтсийн Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн Өндөрхангай сумын татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Сүхбаатарын Энхцэцэг, Дундговь аймгийн татварын хэлтсийн Захиргаа, хуулийн тасгийн хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Ичинхоролын Замэндий, Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн Адаацаг сумын татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Баянмөнхийн Энхжаргал, Луус сумын татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Билгээгийн Ууганбат нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА, АХЛАХ КОМИССАР

Л.СҮХ-ОЧИР